



ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГАН 2019

БАНКНЫ САЛБАР ҮҮСЭЖ
ХӨГЖСӨНИЙ 95 ЖИЛИЙН ОЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ:
ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ



2019 ОНЫ 4 ДҮГЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР
УЛААНБААТАР ХОТ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал болон “Эдийн засгийн бодлогын чуулган 2019”-д оролцогч Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монголбанк нь эдийн засаг, санхүүгийн зах зээл болон макро бодлогод тулгамдаж буй сорилт, асуудлуудын шийдэл, бодлогын боломжит хувилбаруудыг судалж хэлэлцдэг эдийн засгийн бодлогын чуулганыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. ‘Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган’-ыг 2018 оны 1 дүгээр сард ‘Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд’ гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд зохион байгуулсан билээ. Энэхүү чуулга уулзалтын зорилго нь тухайн цаг үед болон ойрын ирээдүйд эдийн засагт тулгамдаж буй сорилт, асуудлуудыг бодлого боловсруулгачид, эрдэмтэн судлаачид, бизнес эрхлэгчид, зах зээлд оролцогчид хамтран судалгаа, шинжилгээнд суурилан хэлэлцэх явдал юм.

Монгол Улсад үндэсний банк, санхүүгийн тогтолцоо үүсэж, хөгжсөний түүхт 95 жилийн ой энэ жил тохиож байна. Иймд энэ жилийн “Эдийн засгийн бодлогын чуулган 2019”-г “Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал”-тай хамтатган “Санхүүгийн салбарын хөгжил: Өнгөрсөн, Одоо, Ирээдүй” гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд зохион байгуулж байна. Энэ хүрээнд “Банкны хөгжил-95 жил”, “Санхүүгийн салбарын дархлааг бэхжүүлэх нь” болон “Финтек: Санхүүгийн зах зээлийн ирээдүй” гэсэн 3 дэд хуралдаанаар хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдөр анх байгуулагдаж, 1925 оны 12 дугаар сарын 9-ны өдөр Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртээр гүйлгээнд анх гаргаж байв. Үндэсний банк байгуулагдаж, үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг гүйлгээнд гаргасан явдал нь орчин цагийн санхүүгийн тогтолцооны суурийг тавьсан юм. Монголбанк 1924-1991 оны хооронд санхүүгийн зуучлал, санхүүгийн системийн хөгжлийг дангаар тодорхойлж байсан бол 1991 онд “Банкны тухай хууль” батлагдсанaar хоёр шатлалт банкны тогтолцоо үүсэж, эрчимтэй хөгжөөд байна. Банк санхүүгийн салбарын түүхэн ололт амжилт, сургамжаа ярилцаж, бодлогын түвшинд цаашид анхаарах асуудлаа хамтдаа хэлэлцэх нь түүхэн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний чухал нэг хэсэг билээ.

Эрүүл санхүүгийн салбартай байх нь эдийн засгийн эрүүл суурийг бүрдүүлэх тул Монголбанкаас банкны салбарын эрсдэл

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсон, Одоо, Ирээдүй”

даах чадварыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар эрчимтэй ажиллаж байна. Монголбанкнаас санхүүгийн салбарын эмзэг байдлыг бууруулах, дархлааг бэхжүүлэх зорилгын хүрээнд макро зохистой бодлогын хэрэгслийг хяналт шалгалтын болон мөнгөний бодлоготой хослуулан ашиглаж эхлээд байна. Үүний зэрэгцээ Монголбанк эрсдэлд сууринсан хяналт шалгалтад шилжих бэлтгэл ажлыг хангаж байна. Иймд макро зохистой бодлого, эрсдэлд сууринсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, макро-санхүүгийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай институцийн тогтолцоо, зохицуулагч байгууллагуудын оролцоо зэргийг хэлэлцэх нь практик тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Финтек нь бидний өдөр тутамд тулгардаг санхүүгийн үйлчилгээтэй холбогдох асуудлуудыг технологийн тусламжтайгаар шийдэх боломжийг олгож байна. Финтек нь төлбөр тооцоо, зээл, мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг хялбарчлаад зогсохгүй нягтлан бодох бүртгэлийн систем, даатгал, блокчэйн, цахим мөнгө, мэдээллийн аюулгүй байдлын технологи зэрэг санхүүгийн олон чиглэлийн үйлчилгээг хамарч байна. Финтекийн хөгжилтэй зэрэгцэн гарч буй өөр нэг чухал асуудал нь цахим аюулгүй байдлыг хангах тухай асуудал юм. Манай улсад ч финтек компаниуд бий болж, төлбөр тооцоо, зээлийн чиглэлээр түлхүү хөгжиж эхлээд байна. Монголбанк Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар тодорхойлсон цахим мөнгө, түүний үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, аюулгүй, найдвартай цахим мөнгөний системийг бий болгож хэрэглэгчийг хамгаалах зорилгоор ‘Цахим мөнгөний журам’-ыг шинээр боловсруулж батлаад байна. Иймд Финтекийг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүний зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах асуудал болон цахим аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар хэлэлцэх нь цаг үеэ олсон чухал сэдэв юм.

Энэ жилийн бодлогын чуулган, эрдэм шинжилгээний хурал нь санхүүгийн зах зээл, эдийн засаг, макро бодлогын түвшинд тулгарч буй сорилтуудыг амжилттай даван туулахад үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАЯРТСАЙХАН

ХӨТӨЛБӨР /Баасан гараг, 4-р сарын 19, 2019/

Бүртгэл

09:00-09:30 | Өглөөний цай

Нээлтийн үг

09:30-10:00 | Г.Занданшатар, Улсын Их Хурлын дарга
Н.Баяртсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч

Дурсгалын зураг

10:00-10:15 |

Хуралдаан 1: Банкны хөгжил-95 жил

Модератор:

С.Дэмбэрэл, Монголбанкны Эдийн засгийн судалгаа,
сургалтын хүрээлэнгийн захирал

Илтгэгч:

Д.Ган-Очир, Монголбанкны Ерөнхий эдийн засагч

“Монгол Улсын эдийн засаг, банкны салбарын хөгжил 95
жилд: Ололт, Сорилт, Сургамж”

10:15-12:15

Хэлэлцүүлэгт оролцогчид:

Б.Баттөмөр, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын
хорооны гишүүн

Ж.Үнэнбат, Монголын банкны холбооны гүйцэтгэх
захирал

М.Болдоо, ХасБанкны гүйцэтгэх захирал

Жан-Паскаль Н.Нгану, Дэлхийн Банкны ахлах эдийн
засагч

Үдийн зоог

12:30-13:30 |

Хуралдаан 2: Санхүүгийн салбарын дархлааг бэхжүүлэх нь

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсөн, Одоо, Ирээдүй”

Модератор:

О.Эрдэмбүлэг, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

Илтгэгч:

Н.Батсайхан, Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал

“Банкны хяналт шалгалтын чиг хандлага”

13:30-15:30

Хэлэлцүүлэгт оролцогчид:

Б.Жавхлан, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүн

Н.Энхбаяр, Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөх

С.Даваасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга

Нил Сэйкэр, Олон улсын валютын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч

Цайны завсарлага

15:30-15:50

Хуралдаан 3: Финтек: Санхүүгийн зах зээлийн ирээдүй

Модератор:

Б.Лхагвасүрэн, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч

Илтгэгч:

Э.Анар, Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал
“Ирээдүй - Финтек”

15:50-17:50

Хэлэлцүүлэгт оролцогчид:

Д.Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга

Р.Мөнхтуяа, ХААН банкны гүйцэтгэх захирлын орлогч

Н.Цэн-Ойдов, Мобифинанс банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх захирал

Лотте Шоу Зибэлл, Азийн хөгжлийн банкны Санхүүгийн салбар хариуцсан дарга

Хэлэлцүүлэг Цаг хуваарилалт

Хуралдаан 1,2,3 (120 минут)

- 1. Модератор** (10 минут)
- 2. Илтгэгч** (20 минут)
- 3. Панелист тус бүр** (10 минут)
- 4. Хэлэлцүүлэг** (50 минут)

ХУРАЛДААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хуралдаан 1

10:15-12:15

Банкны салбар - 95 жил

Монгол Улс мөнгөн гүйлгээний талаар өнө эртний түүхтэй билээ. Манай эриний III зууны сүүлчээр байгуулагдсан Хүннү гүрний үеэс зоосон мөнгө хэрэглэж ирсэн бол Чингис хаан Монголын тулгар төрийг эмхлэн байгуулаад зоос цутгуулан хэрэглэж, 1227 онд цаасан мөнгө хэвлэн гүйлгээнд гаргаж байсан баримт бий. Чингис хааны үе залгамжлагчид Монголын нэгдсэн гүрний уед 100 гаруй төрлийн алт, мөнгө, зэс, гууль, хүрэл зоос цутгуулж, цаасан мөнгийг дахин хэвлүүлж гүйлгээнд гарган таваарын гүйлгээнд хэрэглэж эд баялгаа тооцоолон гадаад гүрнүүдтэй худалдаа наймаа хийж байжээ.

Энэхүү баялаг уламжлал нь ээзэнт гүрний задрал, Манж Чин улсын нөлөөнд явж ирсэн он жилүүдэд уусан арилсан хэдий ч 1921 оны Ардын хувьсгалын дараа үндэсний банк байгуулагдаж, орчин цагийн Монголын санхүүгийн тогтолцооны суурь тавигдсан билээ. Монгол Улсын Засгийн газрын 1922 оны 3 дугаар сарын 27-28-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдөр анх байгуулагдаж байв. Тус банк нь тухайн уед эдийн засагт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих олон чухал бодлогын шийдвэрүүдийг гаргаж байв. Тухайлбал, БНМАУ-ын Их хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газраас 1925 оны 2 дугаар сарын 22-нд мөнгөний шинчлэл явуулах тухай тогтоол гаргаж, Монголын үндэсний мөнгөний нэгжийг “төгрөг” гэж нэрлэхээр тогтжээ. Энэ дагуу 1925 оны 12 дугаар сарын 9-ны өдөр Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртээр гүйлгээнд гаргаж мөнгөний эргэлтийн эмх замбараагүй байдал, олон төрлийн мөнгөний гүйлгээг зогсоожээ. Үндэсний банк байгуулагдаж, үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг гүйлгээнд гаргасан явдал бол орчин цагийн санхүүгийн тогтолцооны суурийг тавив. Монголбанк 1924-1991 оны хооронд санхүүгийн зуучлал, санхүүгийн системийн хөгжлийг дангаар тодорхойлж байсан бол 1991 онд “Банкны тухай хууль” батлагдсанаар хоёр шатлалт банкны тогтолцоо үүсэж, эрчимтэй хөгжөөд байна.

Өнгөрсөн 95 жилд банк, санхүүгийн салбар олон улсын түвшинд хүрч хөгжиж, гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, улс орны бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирлээ. Үндэсний банк байгуулагдсанаас хойш сорилт, ололт амжилтаар дүүрэн он жилүүд өнгөрлөө. Түүхийн хуудаснаас авах сургамж, цаашид эдийн засгийн бодлогын түвшинд анхаарах асуудлыг энэ салбар хуралдаанаар хэлэлцэнэ.

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсөн, Одоо, Ирээдүй”

Хэлэлцэх сэдвүүд

- Банкны салбарт гарсан гол ололт амжилт юу байв?
- Банкны салбарын хөгжлийн цаашдын ирээдүйг хэрхэн харж байна вэ?
- Банкны салбарын түүхэн хөгжлөөс авах гол сургамж, цаашид анхаарах асуудал юу байна вэ?

Модератор

С.Дэмбэрэл

Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал,
Монголбанк



Илтгэгч

Д.Ган-Очир

Ерөнхий эдийн засагч,
Монголбанк



“Монгол Улсын эдийн засаг, банкны салбарын хөгжил 95 жилийн түүхэнд: Ололт, Сорилт, Сургамж”

Панелистууд



Б.Баттөмөр

Эдийн засгийн байнгын хорооны гишүүн,
Улсын Их Хурал



Ж.Үнэнбат

Гүйцэтгэх захирал,
Монголын банкны холбоо



М.Болдо

Гүйцэтгэх захирал,
ХасБанк



Жан-Паскаль Н.Нгану

Ахлах эдийн засагч,
Дэлхийн банк

Хуралдаан 2

13:30-15:30

Дархлаатай санхүүгийн системийг бэхжүүлэх нь

Эрүүл санхүүгийн салбартай байх нь эдийн засгийн эрүүл суурийг бүрдүүлэх тул банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар эрчимтэй ажиллаж байна. Сүүлийн 2 жил гаруй хугацаанд банк санхүүгийн системд хууль эрхзүйн шинэчлэлийг амжилттай хийж байна. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль зэрэг хуулиудыг шинэчлэн батлуулснаар Төв банкны сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэн, бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал үйл явдал байлаа. Монгол Улс нь Ази тивийн орнуудаас хамгийн түрүүнд активын чанарын үнэлгээ (AQR)-г хийлгэсэн орон болов. Активын чанарын үнэлгээний болон холбогдох бусад арга хэмжээний үр дүнг үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тухайлбал, активын чанарын үнэлгээний үр дүнг банкуудын тайланд тусгах, банкуудад өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага тавьж, гүйцэтгэлд хяналт тавих, чанаргүй активыг шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох зэрэг ажлууд хийж байна.

Санхүүгийн салбарын дархлааг бэхжүүлэх нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах суурь билээ. Дэлхийн санхүүгийн хямралын дараагаас макро зохистой бодлого нь санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, дархлааг бий болгоход чухал болохыг онцолж эхэлсэн. Эдийн засгийн өрнөлийн үед эрсдэл бага, харин уналтын үед эрсдэл өндөр байгаа гэж харагддаг нь санхүүгийн системийн ‘мөчлөг дагасан’ үйл хөдлөлд хүргэдэг. Энэ нь санхүүгийн мөчлөгийн тэлэлт, агшилтын далайцыг нэмэгдүүлж, эдийн засгийн мөчлөгийн хэлбэлзлийг ч өсгөдөг. Макро зохистой бодлого нь мөчлөг дагасан үйл хөдлөлтийг хязгаарлах замаар системийн эрсдэлийг бууруулах, макро эдийн засгийн зардлыг бага байлгахад чиглэх бөгөөд мөнгөний бодлогын хэрэгжилтэд ч дэмжлэг үзүүлдэг.

Практик дээр санхүүгийн системийн эрсдэл хуримтлагдаж байгаа эсэхийг тодорхойлох, макро зохистой бодлогын хэрэгслийн нөлөөг бүрэн тооцох нь хүндрэлтэй асуудал хэвээр байна. Үүний зэрэгцээ макро зохистой бодлогыг макро-санхүүгийн тогтвортой байдлын тогтолцоонд хэрхэн оновчтой оруулж ирэх асуудал чухлаар тавигдаж байна. Энэ тогтолцоо нь төсвийн, мөнгөний, бүтцийн, микро зохистой (хяналт шалгалтын) болон макро зохистой бодлогуудын харилцан хослолыг бүхэлд нь хамрах учиртай. Эдгээр бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал юм. Монголбанкнаас санхүүгийн салбарын эмзэг байдлыг бууруулах, дархлааг бэхжүүлэх зорилгын хүрээнд макро зохистой бодлогын хэрэгслийг хяналт шалгалтын болон мөнгөний бодлоготой хослуулан ашиглаж эхлээд байна. Тухайлбал, банкуудын хувь

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсөн, Одоо, Ирээдүй”

нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх, шинээр олгосон хэвийн зээлд 1 хувийн эрсдэлийн сан байгуулах, зээлийн долларжилтыг бууруулах, хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ Монголбанк эрсдэлд сууриссан хяналт шалгалтад шилжих бэлтгэл ажлыг хангаж байна.

Хэлэлцэх сэдвүүд

- Санхүүгийн салбарын эмзэг байдлыг бий болгож буй хүчин зүйлс, авч хэрэгжүүлж буй бодлогын хэмжээнүүдийн үр нөлөө юу байв?
- Макро зохицтой бодлого, эрсдэлд сууриссан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломж, учирч болох хүндрэлүүд юу вэ?
- Санхүүгийн салбарын дархлааг бэхжүүлэх, макро-санхүүгийн тогтвортой байдлыг хангахад Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкны оролцоо, хамтын ажиллагаа хэр байна вэ?

Модератор

О.Эрдэмбилиг

Тэргүүн Дэд
Ерөнхийлөгч,
Монголбанк



Илтгэгч

Н.Батсайхан

Хяналт, шалгалтын
газрын захирал,
Монголбанк



“Банкны хяналт шалгалтын
чиг хандлага”

Панелистүүд



Б.Жавхлан

Эдийн засгийн байнгын
хорооны гишүүн,
Улсын Их Хурал



Н.Энхбаяр

Ерөнхий сайдын Эдийн
засгийн бодлогын
зөвлөх



С.Даваасүрэн

Дарга,
Санхүүгийн зохицуулах
хороо



Нил Сэйкер

Монгол дахь суурин
төлөөлөгч,
Олон улсын валютын сан

Хуралдаан 3

15:50-17:50

Финтек: Санхүүгийн зах зээлийн ирээдүй

Хүн төрөлхтөн аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын босгон дээр ирж интернет технологийг дагаад бүхий л салбарт өөрчлөлт өрнөж байна. Санхүүгийн салбарт ч технологийг даган цоо шинэ салбар бий болсон нь Финтек билээ. Финтек нь технологийн дэвшил, санхүүгийн үйлчилгээний нэгдэл бөгөөд санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хялбар, хямд зардлаар хүртээмжтэй хүргэх шийдэл болж байна. Сүүлийн жилүүдэд ухаалаг гар утасны хэрэглээ идэвхэжсэнээр Финтекийн салбар өнөөгийн хөгжлийн шатанд ирээд байна.

Санхүүгийн салбар уламжлалт үйлчилгээнээс хальж, технологид суурилан хөгжих хандлагатай болсноор ямар боломж, эрсдэл учирч болох тал дээр олон улсын байгууллага, санхүүгийн зохицуулагчид ихээхэн анхаарал хандуулж байна. Финтек нь тухайн орны санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, улмаар тогтвортой, хүртээмжтэй есөлтийг бий болгоход эерэг нөлөөтэй боловч эрх зүйн зохицуулалт үр дүнгүй, оновчтой бус тохиолдолд эрсдэл өсөж, санхүүгийн тогтвортой байдалд ч сөрөг нөлөөтэй. Иймд тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн орчинг бүрдүүлэхийн тулд Финтекийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ бий болж болзошгүй эрсдэлээс хамгаалах үр дүнтэй эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх нь чухал зорилт, сорилт болж байна. Финтекийн хөгжилтэй зэрэгцэн гарч буй өөр нэг чухал асуудал нь цахим аюулгүй байдлыг хангах тухай асуудал юм.

Манай орны хувьд Финтек нь харьцангуй шинэ салбар боловч, энэ чиглэлээр цөөнгүй компаниуд үйл ажиллагаа явуулж эхлээд байна. Иймд санхүүгийн салбарын технологийн шинэчлэлтэй уялдан гарч, ирж буй энэхүү шинэ харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухлаар тавигдаж байна. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар тодорхойлсон цахим мөнгө, түүний үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, аюулгүй, найдвартай цахим мөнгөний системийг бий болгож хэрэглэгчийг хамгаалах зорилгоор Монголбанк ‘Цахим мөнгөний журам’-ыг шинээр боловсруулж батлав. Энэхүү журмыг баталснаар цахим мөнгөний системд хэн, кэрхэн оролцох болон зөвшөөрөл авах үйл явцыг ойлгомжтой болгож, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн эрх, үүргийг тодорхой болгоод зогсохгүй финтек, төлбөрийн системийн цаашдын хөгжлийг дэмжих эрх зүйн орчин бүрдэв. Энэ журмын дагуу Монголбанк Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адилтгах үнэ цэнэ бүхий бэлэн бус төлбөрийн хэрэгслээр тооцогдох Candy цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоод байна.

Энэ салбар хуралдаанд Финтекийг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, түүний зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах асуудал болон цахим аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар хэлэлцэнэ.

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсөн, Одоо, Ирээдүй”

Хэлэлцэх сэдвүүд

- Финтекийн хөгжил, цахим аюулгүй байдлын асуудлаар ямар бодлого, арга хэмжээ авах шаардлагатай байна вэ?
- Финтек боломж уу эсвэл эрсдэл үү?, эрсдэлийг хэрхэн бууруулах вэ?
- Уламжлалт банк, санхүүгийн байгууллагуудтай хамтрах уу эсвэл өрсөлдөх үү?

Модератор

Б.Лхагвасүрэн

Дэд Ерөнхийлөгч,
Монголбанк



Илтгэгч

Э.Анар

Төлбөр тооцооны
газрын захирал,
Монголбанк

“Ирээдүй - Финтек”



Панелистууд



П.Цэн-Ойдов

Гүйцэтгэх захирал,
Мобифинанс банк бус
санхүүгийн байгууллага



Д.Баярсайхан

Дэд дарга,
Санхүүгийн зохицуулах
хороо



Р.Мөнхтүяа

Гүйцэтгэх захирлын
орлогч,
ХААН Банк



Лотте Шоу Зибелл

Санхүүгийн салбар
хариуцсан дарга,
Азийн хөгжлийн банк

ХУРАЛД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Байгууллага	Албан тушаал	Нэр
Улсын их хурал			
1	Улсын их хурал	Улсын их хурлын дарга	Г.Занданшатар
2		Улсын их хурлын гишүүн, Шадар Сайд	Ө.Энхтувшин
3		Улсын их хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга	Д.Дамба-Очир
4		Улсын их хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга	М.Оюунчимэг
5		Улсын их хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга	Б.Чойжилсүрэн
6		Улсын их хурлын гишүүн	Б.Баттөмөр
7		Улсын их хурлын гишүүн	Б.Жавхлан
8		Улсын их хурлын гишүүн	А.Ундраа
9		Улсын их хурлын гишүүн	Н.Учрал
10		Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн	Ц.Мөнхбаяр
11		Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх	Ж.Уянга
12		Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх	С.Энхцэцэг
Гадаад харилцааны яам			
13	Гадаад харилцааны яам	Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар	В.Энхболд
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар			
14	Ерөнхий сайдын ажлын алба	Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх	Н.Энхбаяр
Хүндэт оролцогчид			
15	Хүндэт оролцогчид	Ерөнхий сайд асан	Д.Содном
16		Ерөнхий сайд асан	М.Энхсайхан
17		Сангийн сайд асан	Э.Бямбажав
18		Монголбанкны Ерөнхийлөгч асан	А.Батсүх
19		Монголбанкны Ерөнхийлөгч асан	Л.Пүрэвдорж
20		Гавьяат багш, доктор	Б.Сувд
Монголбанк			
21	Монголбанк	Ерөнхийлөгч	Н.Баяртсайхан
22		Тэргүүн дэд Ерөнхийлөгч	О.Эрдэмбилэг
23		Дэд Ерөнхийлөгч	Б.Лхагвасүрэн
24		Ерөнхий эдийн засагч	Д.Ган-Очир
25		Мөнгөний бодлогын газрын захирал	Б.Баярдаваа
26		Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал	А.Энхжин
27		Дотоод аудитын газрын захирал	Т.Амарсайхан
28		Хяналт, шалгалтын газрын захирал	Н.Батсайхан
29		Хууль, эрх зүйн газрын захирал	Д.Аюуш
30		Судалгаа, статистикийн газрын захирал	Б.Батдаваа

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсөн, Одоо, Ирээдүй”

31	Мөнгөн тэмдэгтийн газрын захирал	Р.Саранцэцэг
32	Мэдээллийн технологийн газрын захирал	Д.Довчинбазар
33	Тайлан бүртгэлийн газрын захирал	Ц.Гарьд
34	Төлбөр тооцооны газрын захирал	Э.Анар
35	Санхүүгийн мэдээллийн албаны захирал	Х.Батчулуун
36	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга	А.Ганбат
37	Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн захирал	Б.Одонтунгалаг
38	Эрсдэлийн удирдлагын албаны захирал	Д.Баянзул
39	Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал	С.Дэмбэрэл
40	Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн дэд захирал	Ц.Батмөнх
41	Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн эдийн засагч	Б.Болдбаатар
42	Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал	Н.Ургамалсувд
43	Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн захирал	Б.Түмэнцэнгэл
44	Хяналт зохицуулалтын хэлтсийн захирал	А.Батсайхан
45	Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал	Ц.Алдармаа
46	Үндэсний цахим гүйлгээний төвийн захирал	Б.Банзрагч
47	Судалгааны хэлтсийн захирал	Л.Даваажаргал
48	Тамгын газрын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн захирал	Г.Нямсүрэн
49	Банкны бодлого, бүтцийн өөрчлөлтийн хэлтсийн ахлах хянан шалгагч	Г.Борхүү
50	Санхүүгийн зах зээлийн хэлтсийн ахлах эдийн засагч	Б.Мөнхзул

Монгобанкны хяналтын зөвлөл

51	Хяналтын зөвлөл	Хяналтын зөвлөлийн гишүүн	Л.Дондог
52		Хяналтын зөвлөлийн гишүүн	М.Энх-Амгалан
53		Хяналтын зөвлөлийн гишүүн	Б.Лхагважав

Сангийн яам

54	Сангийн яам	Сангийн сайд	Ч.Хүрэлбаатар
55		Төрийн нарийн бичгийн дарга	С.Наранцогт
56		Санхүүгийн бодлогын газрын дарга	Ц.Зоригтбат
57		Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга	Ж.Ганбат
58		Эдийн засгийн бодлогын газрын дарга	Г.Батхүрэл

Санхүүгийн зохицуулах хороо

59	Санхүүгийн зохицуулах хороо	Дарга	С.Даваасүрэн
60		Дэд дарга	Д.Баярсайхан
61		Ажлын албаны дарга	Б.Ариунаа
62		Үнэт цаасны газрын дарга	Б.Лхагвасүрэн

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

63	Төрийн өмчийн бодлого	Дарга	Б.Ганбат
----	-----------------------	-------	----------

Эдийн Засгийн Бодлогын Чуулган 2019
“Банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал”

	зохицуулалтын газар		
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам			
64	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	Г.Нандинжаргал
Үндэсний аудитын газар			
65	Үндэсний Аудитын газар	Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор	С.Бурэнбат С.Оюунбилэг
Үндэсний статистикийн хороо			
67	Үндэсний статистикийн хороо	Дарга	А.Ариунзаяа
68		Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга	А.Дэмбэрэл
69		Эдийн засгийн статистикийн газрын дарга	Э.Эрдэнэсан
Үндэсний хөгжлийн газар			
70	Үндэсний хөгжлийн газар	Дарга	Б.Баярсайхан
71		Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Ж.Должинсүрэн
72		Судалгаа, шинжилгээний газрын дарга	А.Мөнхболд
Хууль зүй, дотоод хэргийн яам			
73	Хууль зүй, дотоод хэргийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	Г.Билгүүн
74		Хууль зүйн бодлогын газрын дарга	П.Сайнзориг
Олон улсын байгууллагууд			
75	Азийн хөгжлийн банк	Азийн хөгжлийн банкны Санхүүгийн салбар хариуцсан дарга	Лотте Шоу-Зибелл
76		Ахлах эдийн засагч	Деклан Магий
77		Зөвлөх	Кэн Хэндри
78		Зөвлөх	Найжил Файр
79		Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн	Антон Дидэнко
80		Зөвлөх	Мари Валdez
81	Дэлхийн банк	Ахлах эдийн засагч	Жан-Паскаль Н. Нгану
82		Эдийн засагч	Б.Даваадалай
83		Эдийн засагч	Ш.Алтанцэцэг
84	Европын сэргээн босголт хөгжлийн банк	Монгол дахь суурин төлөөлөгч	Ирина Кравченко
85		Санхүүгийн байгууллага хариуцсан банкир	Т.Энэрэл
86	ЖАЙКА	Суурин төлөөлөгч (Засаглал)	А.Сайхантуяа
87	Олон улсын валютын сан	Монгол дахь суурин төлөөлөгч	Нэйл Сакер
88		Эдийн засагч	Б.Ардак
89		Эдийн засагч	С.Сэлэнгэ
90		Эдийн засагч	Б.Хулан
Холбоод, бусад байгууллагууд			
91	Монголын банкуудын холбоо	Гүйцэтгэх захирал	Ж.Үнэнбат
92	Монголын банк бус санхүүгийн	Ерөнхийлөгч	З.Алтанзул

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсөн, Одоо, Ирээдүй”

	байгууллагуудын холбоо		
93	Монголын ипотекийн корпораци	Гүйцэтгэх захирал	Б.Гантулга
94	Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо	Гүйцэтгэх Захирал, Удирдах зөвлөлийн гишүүн	Б.Найдалаа
95	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Ерөнхийлөгч	О.Амартувшин
96	Монголын хөрөнгийн бирж	Гүйцэтгэх захирал	Х.Алтай
97	Хадгаламжийн даатгалын корпораци	Гүйцэтгэх захирал	Х.Бум-Эрдэнэ
98	Улаанбаатар Төмөр зам ХНН	Дарга	Д.Жигжиднямаа
99	Эрдэнэс Монгол ХХК	Гүйцэтгэх захирал	П.Ганхүү
100	Эрдэнэс-Таван толгой ХК	Гүйцэтгэх захирал	Б.Ганхуяг
101	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	Ерөнхий захирал	Х.Бадамсүрэн
102		Санхүү, эдийн засаг хариуцсан захирал	Д.Үүрийнтуяа
103		Эдийн засгийн хэлтсийн дарга	Б.Гөлгөө
104		Эдийн засгийн хэлтсийн орлогч дарга	Д.Галбаатар

Банкууд

105	Ариг банк	Гүйцэтгэх захирал	Д.Төмөрхүү
106	Богд банк	Гүйцэтгэх захирал	Г.Саруул
107	Голомт банк	Ерөнхийлөгч	Г.Ганболд
108		Гүйцэтгэх захирал	Ө.Ганзориг
109		Эдийн засагч	Э.Тэмүүжин
110		Эрх хүлээн авагч	М.Адилбиш
111	Капитрон банк	Гүйцэтгэх захирал	Л.Ариунаа
112	Монгол Улсын Хөгжлийн банк	Гүйцэтгэх захирал	Б.Батбаяр
113	Монгол Улсын Хөгжлийн банк	Төслийн санхүүжилт, зээлийн газрын захирал	Ч.Мөнхбаяр
114	Төрийн банк	Гүйцэтгэх захирал	Г.Дөлгөөн
115	Тээвэр хөгжлийн банк	Гүйцэтгэх захирал	М.Отгонбаяр
116	Улаанбаатар хотын банк	Гүйцэтгэх захирал	А.Энхмэнд
117	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	Гүйцэтгэх захирал	Б.Тулга
118	ХААН Банк	Гүйцэтгэх захирлын орлогч	Р.Мөнхтуяа

Эдийн Засгийн Бодлогын Чуулган 2019
“Банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал”

119	Хадгаламж банк	Эрх хүлээн авагч	М.Энхтөр
120	Хас банк	Гүйцэтгэх захирал	М.Болдоо
121	Худалдаа хөгжлийн банк	Гүйцэтгэх захирал	О.Орхон
122	Чингис хаан банк	Гүйцэтгэх захирал	С.Сандагдорж
123	Кредит банк	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч	А.Сандагсүрэн
Бусад хувийн хэвшлийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд			
124	Ард кредит ББСБ	Гүйцэтгэх захирал	Ч.Ганзориг
125	Ард санхүүгийн нэгдэл	Гүйцэтгэх захирал	Ч.Ганхуяг
126	Гэрэг партнэрс	Захирал	Г.Рагчаасүрэн
127	Гэрэгэ системс	Гүйцэтгэх захирал	Ц.Эрдэнэбат
128	ККТТ ХХК	Гүйцэтгэх захирал	Д.Даваа
129	ЛэндМН ББСБ	Гүйцэтгэх захирал	Б.Гантулга
130	Мобифинанс ББСБ	Гүйцэтгэх захирал	П.Цэн-Ойдов
131	МОСТ ФинТек	Гүйцэтгэх захирал	А.Сүхдорж
132	Young Presidents Organization Mongolia Chapter	Тэргүүн	Н.Мөнхнасан
Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн мэдээлэл бэлтгэдэг агентлагууд			
133	Дефакто институт	Гүйцэтгэх захирал	Д.Жаргалсайхан
134	Bloomberg TV Mongolia	Гүйцэтгэх захирал	Э.Долгион
135	Mongolian Economy	Эрхлэгч	Д.Бэхбаяр
136	Mongolian Mining Journal	Гүйцэтгэх захирал	Л.Батбаяр
Их сургуулиуд, бие даасан шинжээчид			
137	Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (NRGI)	Менежер	Н.Дорждарь
138	Монгол Улсын Их сургууль	Санхүү толовлют хариуцсан дэд захирал	Ч.Ундрям
139		Бизнесийн сургуулийн захирал, профессор	Ч.Энхбаяр
140		Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч, Дэд профессор	С.Дөлбадрах
141		Монголын эдийн засгийн хүрээлэнгийн захирал, Профессор	Х.Цэвэлмаа
142		Бизнесийн сургуулийн профессор багш, доктор	Н.Батнасан
143		Бизнесийн сургуулийн багш, дэд профессор, доктор	А.Энхбат
144		Профессор	Б.Санжмятав
145		Дэд профессор	Ч.Нарантуяа
146		Профессор	Б.Эрдэнэбат
147		Доктор, зөвлөх профессор	Д.Дуламсүрэн

Санхүүгийн Салбарын Хөгжил:

“Өнгөрсон, Одоо, Ирээдүй”

148	Монголын Эдийн засгийн шинжилгээ судалгааны төв (MeARC)	Гүйцэтгэх захирал	Г.Бумчимэг
149	Монгол-Японы төв	Захирал	Ц.Даваадорж
150		Захирал асан	Д.Батжаргал
151	Санхүү, эдийн засгийн их сургууль	Доктор, Профессор, Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн	Ц.Батсүх
152		Санхүүгийн удирдлагын тэнхимиийн Дэд профессор	Ж.Дэлгэрсайхан
153		Экономиксийн тэнхимиийн эрхлэгч	Д.Мөнхцэцэг
154	Удирдлагын Академи	Захирал, профессор	С.Зүльфикар
155		Дэд захирал	Ш.Батсүх
156	Үндэсний стратегийн хүрээлэн	Гүйцэтгэх захирал	Б.Мөнхсоёл
157	Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	А.Долгион
158	Хөдөө аж ахуйн их сургууль	Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан дэд захирал	Ж.Батчулуун
159	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	Захирал, Доктор, профессор	М. Должин
160		Академич, ШУА-ийн Ерөнхийлөгч	Д.Рэгдэл
161		Академич, ШУА-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч	Г.Чулуунбаатар
162	Шинжлэх ухааны академи	Академич, Улаанбаатар Эрдэм их сургуулийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Т.Дорж
163	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв	Судлаач	Золбаяр
164	Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)	Судлаач	Т.Дөлгөөн
165	Эдийн засгийн үндэсний дээд сургууль	Доктор, багш	Л.Оюун
166	Этүгэн их сургууль	Академич, Этүгэн их сургуулийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	С.Нямзагд
167	NRCC	Захирал, МУИС профессор	Б.Алтанцэцэг

Эдийн Засгийн Бодлогын Чуулган 2019
“Банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн эрдэм шинжилгээний хурал”

ТЭМДЭГЛЭЛ
